

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Г.ГАРИУНБУЯН

2020 оны 02-р сарын 19-ны өдөр

**ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН АНГИ, БАЙГУУЛЛАГУУДЫН
ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ АВТОМАШИН, ТЕХНИК, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЭЛТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН ХӨДӨЛМӨРИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БЭЛЭН БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЭГДСЭН АРГА
ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Онцгой байдлын ерөнхий газрын 2020 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудын Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар бүлгийн алба хаагчдын ой, хээрийн гал түймэр унтраах хүн нэг бүрийн багаж хэрэгсэл, автомашин, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэхэд оршино.

Хоёр. Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах хугацаа, хамрах хүрээ

2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл хугацаанд төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах анги, салбар бүлгүүд зохион байгуулна.

Гурав. Ажлын чиглэл

Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар бүлгүүд удирдамжийн хүрээнд дараах чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн 5 дугаар бүлгийн 3.5, 3.44-т заасныг хэрэгжүүлэн алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулах, хачигт халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулах тарилга хийлгэх.

2. Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах анги, салбарууд Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн 4 дүгээр хавсралтын дагуу эмийн санг бүрдүүлж бэлэн байдлыг хангах.

3. Төв орон нутгийн Онцгой байдлын газрын дарга нар харъяа орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагатай хамтран ой, хээрийн түймрийн голомтод ажиллах эмчийн бүрэлдэхүүнийг томилж эмнэлгийн тусгай хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

4. Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах анги, салбарууд Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн 5 дугаар 4.28-т заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн түймэрт ажиллах бие бүрэлдэхүүнийг байршлаа мэдээлэх, дуут дохио, гэрэлт пуужин, (дуурайлган үзүүлэх хэрэгсэл утаат шашки) хэрэгслээр хангах нөөц бүрдүүлэх.

5. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1.2.4, 10.3 дахь хэсэгт заасны дагуу орон нутгийн хэмжээнд байгуулагдсан гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн нарийвчилсан судалгааг гаргах. /загвар хүснэгт № 1/

6. Онцгой байдлын газрын хэмжээнд ой, хээрийн гал түймэр унтраах зориулалтын автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон хөдөлмөр хамгааллын хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэлд үзлэг шалгалт, засвар

үйлчилгээг хийж бэлэн байдлыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх салбарын хэмжээнд ашиглагдаж байгаа ой, хээрийн түймэртэй тэмцэх автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгааг загвар хүснэгт №2-ын дагуу гаргах.

7. Ой, хээрийн гал түймрийн бүртгэлийг шинэчилсэн хүснэгтийн дагуу бүртгэж шаардлагатай тохиолдолд Гал түймэртэй тэмцэх газарт шуурхай ирүүлэх /загвар хүснэгт №3-ыг Онцгой байдлын ерөнхий газрын веб сайт (meta.gov.mn)-ын Газар хэлтэс цэсний Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналт хэсэгт байрлуулсан болно/

Дөрөв: Тайлан, мэдээнд тавигдах шаардлага

1. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг газар, хэлтсийн даргаар баталгаажуулан хийсэн ажлын үр дүнгийн талаарх тайланг танилцуулж, үр дүнг тооцуулан баталгаажуулж ирүүлнэ.

2. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлсэн ажил, орон нутгийн хэмжээнд гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулсан Засаг даргын захирамж, тушаал шийдвэр, хүн, хүч, техник, багаж хэрэгслийн судалгааг загвар хүснэгт №1-ийн дагуу гаргаж хавсралтаар ирүүлэх.

3. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн 4 дүгээр хавсралтын дагуу бүрдүүлсэн эмийн сангийн фото зургийг ирүүлэх.

4. Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах салбарт ашиглагдаж байгаа ой, хээрийн түймэртэй тэмцэх автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгааг загвар хүснэгт №2-ын дагуу гаргаж цахимаар Гал түймэртэй тэмцэх газарт ирүүлнэ.

5. Ой, хээрийн гал түймрийн бүртгэлийг шинэчилсэн загвар хүснэгт №3-ын дагуу бүртгэж Гал түймэртэй тэмцэх газарт цахимаар ирүүлэх.

6. Удирдамжийн дагуу зохион байгуулсан арга хэмжээний үр дүн, ололт амжилт, албаны хэмжээнд ой, хээрийн гал түймрийн үед шаардлагатай багаж хэрэгсэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал тусгасан байна.

Жич: Хэд, хэдэн гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар бүлэгтэй газар, хэлтсүүд анги тус бүрээр үүрэг даалгавар өгч зохион байгуулна.

Тав. Мэдээ тайлан ирүүлэх талаар

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр цахим хэлбэрээр /[Skype OBEG gal tuimertei temtseh gazar_untraahheltes@yahoo.com](mailto:Skype_OBEG_gal_tuimertei_temtseh_gazar_untraahheltes@yahoo.com)/ хаягаар, 03 дугаар сарын 16-ны өдрийн дотор Гал түймэртэй тэмцэх газарт албан бичгээр ирүүлсэн байна.

Зургаа. Дүгнэх талаар

1. Нэгдсэн удирдамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайланг хүлээн авч нэгтгэн үнэлгээ, дүгнэлт өгч Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулна.

2. Удирдамжийн хүрээнд ой, хээрийн гал түймэр унтраах арга ажиллагаатай холбоотойгоор шинээр санаачилсан ажил, бүтээлч арга нэвтрүүлсэн хамт олныг урамшуулах, хангалтгүй зохион байгуулсан удирдах албан тушаалтанд цэргийн албаны сахилгын дүрэмд заасны дагуу хариуцлага тооцож ажиллана.

ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН АНГИ, БАЙГУУЛЛАГУУДЫН
ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ АВТОМАШИН, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
БАГАЖ ХЭРЭГСЭЛТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БЭЛЭН БАЙДЛЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖИЙН МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ

Огноо

№	Газар, хэлтэс, анги салбар	Эрүүл мэндийн үзлэг, тарилга хийлгэсэн байдал			Дуут дохио, гэрэлт пуужингийн хангалт		Засвар үйлчилгээ хийсэн байдал			Сайн дурын хэсгийн судалгаа								
		Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан алба хаагчдын тоо	Тарилгын төрөл, нэр	Хамрагдсан алба хаагчдын тоо	Бурдуулсан эмийн сангийн тоо	Дуут дохио, гэрэлт пуужингийн нэр, төрөл	Тоо	Машины тоо	Техникийн тоо	Багаж хэрэгслийн тоо	Засаг даргын СДХ байгуулсан захирамжийн он, сар, өдөр дугаар	СДХ байгуулсан аймаг, дүүрэг	СДХ эсэг байгуулагдсан сум, хорооны нэр, дугаар	СДХ эсгийн алба хаагчдын тоо	Автомашинны тоо	Багаж хэрэгслийн нэр		Багаж хэрэгслийн тоо
1															1	2	1	2
2																		

ТАНИЛЦСАН:
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА:

МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ ГАРГАСАН:

..... ГАЗРЫН АНГИЙН
 ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ АВТОМАШИН, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
 БАГАЖ ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА

Огноо

№	Газар, хэлтэс, анги	Автомашин техник				Багаж хэрэгсэл																
		Ой, хээрийн гал түймэр унтраах автомашины төрөл, марк	Тоо	Усны багтаамж	Квадратцикл нэр, марк	Тоо	Үлээгч аппаратны тоо	Цураадагчийн тоо	Мотопомпы тоо /ус дамжуулах хоолойны хамт/	Үүргийн гал унтраагуул /РЛО/-ны тоо	Усны нөөц сав литр	Тоо	Холбооны хэрэгслийн тоо	Зөөврийн цахилгаан үүсгүүрийн тоо	Моторт хөрөөний тоо	Төрсөсөн шүүрний тоо	Цохиурны тоо	Хүрэнний тоо	Сүхны тоо	Гар хөрөөний тоо	Бусад	
1																						
2																						

ТАНИЛЦСАН:

СУДАЛГАА ГАРГАСАН: